



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2018 оны 02 дугаар сарын 22

№ 01/42 ДУА-2018/23/СГА-ТЦЗ Мандалговь хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Баянжаргалан сумын Соёлын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд санхүүгийн аудит хийх явцад нийт 2,140,000.00 /хоёр сая нэг зуун дөчин мянган/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ.

1. Нярав кассын орлогыг тушаахдаа өөрийн дансаар дамжуулан гүйлгээ хийсэн. Орлогыг журамд заасан хугацаанд төвлөрүүлээгүй. Энэ нь Сангийн сайдын “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д /Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана./, 3.13-т /Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын тооцоог гаргаж тайланг тушаана./, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./ заасныг;
2. Үнэт цаас, үзвэр үйлчилгээний орлогыг хүдээн авч дансанд тушаахдаа анхан шатны баримт хөтлөөгүй, бэлэн мөнгөний тайлан гаргаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/ Сангийн сайдын 2012 оны 276 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.3-т /Журмын 2.2-т зааснаас бусад зардлаас зайлшгүй бэлнээр гүйлгээ хийлгэх шаардлагатай тохиолдолд албан хүсэлт, шаардлагатай хөрөнгийн баталсан төсөв, бэлнээр авах үндэслэлийг тодорхой тусгаж ирүүлнэ. Төрийн сан албан хүсэлтийг хянаж үзэн шаардлагатай гэж үзвэл бэлнээр олгож болно/ 3.10-д /Мөнгөн кассаар дамжуулан хийгдэх гүйлгээ бүрт орлого зарлагын баримтыг бичнэ/ заасныг тус тус зөрчсөн байна.



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-д/Аудитын явцад шэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн

аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.5-т /Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийг хангаагүй/, 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй/ гэж заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Бэлэн мөнгийг ажлын 1 өдрийн дотор багтаан байгууллагын дансанд тушааж байх,
2. Бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт хөтөлж, тайланг тухай бүр гаргах,
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянжаргалан сумын Соёлын төвийн эрхлэгч Б.Батчимэг, нягтлан бодогч О.Ууганбаатар нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
АУДИТОР  Б.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:
ЭРХЛЭГЧ  Б.БАТЧИМЭГ
НЯГТЛАН БОДОГЧ  О.УУГАНБААТАР

¹Албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-т /Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтанг ажлаас халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ/